

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭХ, ХҮҮХЭД НӨХӨН ҮРЖИХҮЙН, ЭРҮҮЛ МЭНД АРГА ХЭМЖЭЭ 2021-2024 ОН ХҮРТЭЛХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2024 оны 11-р сарын 07.

Дундговь аймаг ЭМГ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая, төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
ЗОРИЛТ 1. Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх зүйн орчинг сайжруулж, түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх:						
1	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-д 2023 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах	-	Хэрэгжилтийг танилцуулсан байна.	Зөвлөмж гарсан байна	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-д 2023 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг албан бичгээр хүргүүлж тусламж үйлчилгээг сайжруулах зөвлөмжийг 7 арга хэмжээ төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилт 94,1 хувьтай байна.	100
2	Өрх, сумдын Засаг даргатай байгуулах гэрээнд эх, хүүхдийн эндэгдэл, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг тусгаж дүгнэх	-	Гэрээний хэрэгжилт	Шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг үнэлсэн байна.	Аймгийн Засаг дарга, Боржигонмандал, Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан гэрээг Эрүүл мэндийн сайдын шинэчлэн баталсан 2024 оны 122 дугаар тушаалын дагуу байгууллаа. Гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар Боржигонмандал өрхийн эрүүл мэндийн төв 82,4, Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төв 94,5 хувьтай тус тус дүгнэгдлээ. Эх хүүхдийн эндэгдэл, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн чиглэлээр 4 заалт оруулсан.	100


ЗОРИЛТ 2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний нөөцийг бэхжүүлэх, зохистой удирдах:


1	“Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй” удирдамжаар сургалт зохион байгуулах	УТХО 1,2	Зохион байгуулсан сургалт хамрагдсан эмч мэргэжилтэний тоо	Сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн зөвлөх эмч Ж.Энхтуяатай хамтран “Жирэмслэлт ба төрөлтийн хүндрэлийг удирдах”- онол дадлагын сургалтыг 2024 оны 6 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд аймгийн төвд зохион байгууллаа. Сургалтын хөтөлбөрт орон нутагт зохихилон тохиолддог жирэмслэлт төрөлтийн үеийн хүндрэлийн 17 сэдвээр онолын мэдээлэл өгч эмч нарын үр чадварыг сайжруулах дадлага ажлыг хийсэн. Сургалтад анхан болон лавалгаа шатлалын эмнэлгийн 40 эмч, эх баригч нар оролцож сургалтын үр дүнд мэдлэгийн түвшин 15 хувиар нэмэгдсэн байна.	100
2	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор “Туршлага судлах уулзалт”-ыг зохион байгуулах	УТХО 1,5	Туршлага судласан эмнэлэг болон эмч мэргэжилтний тоо, нэвтрүүлсэн туршлага	Уулзалтыг зохион байгуулсан байна.	Жирэмсний нэрийн хяналтыг нэвтрүүлэх чиглэлд туршлага судлах арга хэмжээг Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэгт зохион байгуулж 17 байгууллагын 20 эмч мэргэжилтэн хамрагдлаа. Жирэмсний хяналтыг сйажруулах,хяналтанд дуудах ,зөвлөгөө өгөх ,харилцан мэдээлэл солилцох чиглэлээр эхчүүдийн дунд нийгтийн сүлжээнд груп үүсгэж ажиллуулдаг туршлагыг эрүүл мэндийн төвүүд хэрэгжүүлж эхлээд байна.Цаашид эцэг эхчүүдэд зөвлөгөө нярайн асаргааны чиглэлд өгдөг өрөө байгуулахаар ажиллаж байна.	100
3	Нярайн эрт илрүүлэг болон нярайн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	ДЭМБ 24,3 УТХО 3,9	Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо, хувь	Нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан байна.	Хүүхдийн дархлаажуулалтад шаардлагатай 6 нэр төрлийн нийт 24,3 сая төгрөгний өртөг бүхий тоног төхөөрөмжийг ДЭМБ-ын санхүүжилтээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нярайн ор, биллиметрээр хангасан. Нярайн тусламж үйлчилгээний нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 82,0 хувьтай байна.	100
4	Өсвөр үе судлал, охидын эмчийг төрөлжсөн мэргэшлээр суралцах боломжтой мэргэжлийн жагсаалтад эх барих,	УТХО 2,6	Мэргэжил дээшлүүлсэн эмчийн тоо	Эх барих эмэгтэйчүүдийн эмчээс өсвөр үе судлал, охидын эмч бэлтгэж эхэлсэн байна	Эх барих эмэгтэйчүүдийн 1 их эмчийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтад хамруулсан.	100


	эмэгтэйчүүдийн эмчийг нэмж шинэчлэх					
5	Олон нийтэд түшиглэсэн ХӨЦМ-ийн сургалт зохион байгуулах	УТХО 1,0	Хамрагдсан эмч мэргэжилтний тоо	Сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон байна	Хүүхдийн өвчний цогц менежмэндийн сургалтыг хамрагдаагүй болон шинээр төгссөн эмч нарт нийт 15 эмчид зохион байгууллаа. Сургалтыг хүүхдийн их эмч Х.Жаргал, Б.Энхбаяр нар удирдан хийлээ.	100
6	Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж, үйлчилгээг үзүүлэх сургуулийн эмч, эрүүл мэндийн анхан шатны эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах	УТХО 0,3	Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо	Өрх, сургуулийн эмч нарт өсвөр үеийнхний эрүүл мэндийн хэрэгцээг ойлгож, ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулсан байна	Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу сургууль цэцэрлэгийн эмч нарт "Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй", "Өсвөр үеийнхэний эрүүл мэнд", "Хөвгүүдийн эрүүл мэнд" зэрэг сэдвээр 29 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа. "Найз байя" үе тэнгийн сургагч, багш, эмч нарт зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр, "Танд асуулт байна уу?" өсвөр үеийнхэнд зориулсан гарын авлагыг 290 ширхэгийг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд тараалаа. Өсвөр насны 681 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмчлүүлэх шаардлагатай 35 хүүхдийг нарийн мэргэжлийн хүүхдийн эмчрүү илгээж, эмчилгээ оношилгоо хийлгэлээ. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй сургууль цэцэрлэгийн насны хүүхдийн Гарын эрүүл ахуй, Шүдний эрүүл ахуйн төсөлийг хэрэгжүүлж, энэ чиглэлд сургууль, цэцэрлэгийн эмч нарт сургалт зөвлөгөө өглөө.	100
ЗОРИЛТ 3. Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тандалтыг сайжруулж, тэргүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хийх, нотолгоонд суурилан орчин үеийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж, нутагшуулах						
1	Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээнд мөрдөгдөж	-	Стандарт удирдамжын	18 нэгжид үнэлгээ хийж, зөвлөмж	Дэрэн, Цагаандэлгэр, Говьугтаал, Дэлгэрцогт, Өндөршил сумдын эрүүл мэндийн төвүүдийн жирэмсний хяналтын өрөө болон төрөх өрөөний зохион байгуулалт, хянагдаж	100



	байгаа удидамж, заавар, журмын хэрэгжилтийг үнэлэх		хэрэгжилтийн хувь	хүргүүлсэн байна.	байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийн товллын хяналт болон үзүүлж буй тусламж, үйлчилгээ, төрөх өрөөний бэлэн байдал, төрсний дараах эх, нярайн хяналтыг үзүүлж байгаа байдал, тушаал шийдвэрийн хэрэгжилт зэрэгт дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжийг өглөө. Стандарт удирдамжийн хэрэгжилт 88 хувьтай байна.									
2	Төрөлтөд бэлтгэхэд зүү эмчилгээг хэрэглэж байгаа үр дүнг тооцсон судалгаа хийх	УТХО 1,0	Судалгаа хийгдсэн тоо	Эмчилгээний үр дүнг тооцсон байна.	Уламжлалт ургийн эргүүлэг-13, төрөлт сэдээх зүү-20 хүнд тус тус хийсэн. Ургийн эргүүлэг нь 98 хувьтай байгаа бөгөөд цаашид үр дүнтэй эмчилгээ болсон.	100								
					<p>Төрөлт сэдээх зүү эмчилгээ</p> <table border="1"> <thead> <tr> <th>Категори</th> <th>Утга</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нийт хүний тоо</td> <td>27</td> </tr> <tr> <td>Сайжирсан</td> <td>96%</td> </tr> <tr> <td>Хэвэндээ</td> <td>4%</td> </tr> </tbody> </table>	Категори	Утга	Нийт хүний тоо	27	Сайжирсан	96%	Хэвэндээ	4%	
Категори	Утга													
Нийт хүний тоо	27													
Сайжирсан	96%													
Хэвэндээ	4%													
					<p>Нийт хүний өртөсөвргээгүй</p> <table border="1"> <thead> <tr> <th>Категори</th> <th>Утга</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нийт хүний өртөсөвргээгүй</td> <td>12</td> </tr> <tr> <td>Өртөсөвргээгүй</td> <td>10 (98%)</td> </tr> <tr> <td>Өртөсөвргөсөн</td> <td>2 (2%)</td> </tr> </tbody> </table>	Категори	Утга	Нийт хүний өртөсөвргээгүй	12	Өртөсөвргээгүй	10 (98%)	Өртөсөвргөсөн	2 (2%)	
Категори	Утга													
Нийт хүний өртөсөвргээгүй	12													
Өртөсөвргээгүй	10 (98%)													
Өртөсөвргөсөн	2 (2%)													
3	Нярайн ретинопатийн эрт илрүүлэг оношлогооны аргыг нэвтрүүлэх	УТХО 20,0	Эрт илрүүлэгт хамрагдсан	Нүдний эмгэгийг эрт илрүүлж	Ретинопатия илрүүлэг үзлэгийг 34 долоо хоногтойгоос доош төрсөн 11 нярай бүрд үзлэг хийснээс ретинопатия 7	100								

			дутуу нярайн эзлэх хувь	оношлосон байна	тохиолдлыг илрүүлж нүдний эмчид үзүүлж ЭХЭМҮТөвд шилжүүллээ. Хамрагдалт 100 хувь	
ЗОРИЛТ 4.Хүн амын дунд эх, хүүхэд , нөхөн үржихүйн чиглэлээр орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндийн боловсрол олгож мэдлэг, хандлага, дадлыг дээшлүүлэн, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах замаар ээлтэй орчин бүрдүүлэх:						
1	“Гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр иргэдийг соён гэгээрүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх.	УТХО 1,0	Хамрагдсан иргэдийн тоо	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ	“Гэр бүл төлөвлөлт” сэдэвт сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 380 сурагч, 985 иргэнд зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан иргэний 16,2 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч нарт “Амны хөндийн эрүүл ахуй”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Өсвөр үеийн эрүүл мэнд” сэдвээр сургалтыг 35 эмч нарыг хамруулан зохион байгуулсан.	100
2	“Өсвөр үеийн эрүүл мэнд”, “Охидын жирэмслэлт” сэдвээр сурталчилгаа хийх.	УТХО 0,5	Хамрагдсан хүүхдийн тоо	Хүүхдүүдийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдсэн байна	 “Өсвөр үеийн эрүүл мэнд”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдэвт сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 751 сурагчыг хамруулан зохион байгуулав. Сургалтад хамрагдагсдын 271 буюу 36 хувь нь эрэгтэй сурагчид байна.	100
3	“Эхийн сүүгээр хооллох 7 хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлж эхийн сүүгээр хооллолтын ач холбогдлыг сурталчилан таниулах арга хэмжээг хэрэгжүүлэх	УТХО 0,5	Сурталчилгаа хийсэн тоо, хамрагдсан иргэдийн тоо	Арга хэмжээ зохион байгуулагдсан байна	Эрүүл, аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны календарчилсан төлөвлөгөөний дагуу “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих Дэлхийн 7 хоног” аяныг 8 дугаар сард “ЯЛГААГ АРИЛГАЯ: БҮХ ЭХЧҮҮДИЙГ ХҮҮХДЭЭ ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОХЫГ ДЭМЖИЦГЭЭЕ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж 15 удаагийн сургалтыг зохион байгуулж 348 хүнийг хамруулан эрүүл мэндийн боловсрол олгов. Тэмдэглэлт өдрийн хүрээнд эхийн сүүгээр хооллолтын талаар постер, видео зөвлөмж, шторк хэлбэрээр цахим сайтад мэдээллийг байршуулсныг 5024 хүн үзэж мэдээлэл авсан байна. Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн төвүүдээс төрөх болон төрсөн эхчүүдэд “Хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллохын ач холбогдол” сэдэвт сургалтыг 314 эмэгтэй, 145 ар гэрийнхэн нийт 459 хүнд зохион байгуулсан байна.	100

					Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт "Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолт", "Гамшигийн үеийн хариу арга хэмжээний хүрээнд нялх, бага насны хүүхдийн хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх" сургалтыг тус тус зохион байгууллаа.	
4	Жирэмснээс хамгаалах арга хэрэгсэл болон бэлгэвчийг зөв хэрэглэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах	УТХО 0,5	Хамрагдсан иргэдийн тоо	Сургалт зохион байгуулсан байна	 <p>Жирэмснээс сэргийлэх гэр бүл төлөвлөлтийн аргад сургах сургалт сурталчилгааг эмнэлэг эрүүл мэндийн төвүүдээр нийт 985 иргэнд хийсэн байна. Эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх газраар үйлчлүүлж байгаа эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 200 удаа, төрөх тасагт хэвтэн эмчлүүлж буй жирэмсэн эхчүүдэд 185 удаа тус тус хийлээ. Жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэгсэл, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр 194 эмэгтэйчүүдэд сургалт хийлээ. Үүний үр дүнд он гарсаар 10 эмэгтэй үр хөндөлт хийлгэхээс татгалзсан байна.</p> <p>Политехникийн коллеж, Ерөнхий боловсролын сургуулуудын 11-12 дугаар ангийн 486 сурагчид болон сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудыг хамруулан "Охидын жирэмслэлт", "Жирэмснээс хамгаалах арга" сэдэвт сургалтыг 11 удаа зохион байгуулж явуулан эрүүл мэндийн боловсрол олгосон.</p> <p>Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудаас "Жирэмснээс хамгаалах арга", "Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс сэргийлэх нь" зэрэг сэдэвт сургалт, мэдээллийг үйл ажиллагааг нийт 31 удаа зохион байгуулж 625 хүнийг хамруулсан байна</p>	100
5	"Оюутны эрүүл мэндийг дэмжих" аяныг зохион байгуулж оюутан залууст эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг зохион байгуулах, эрүүл мэндийн	УТХО 0,5	Хамрагдсан оюутан сурагчдын тоо	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна	<p>Эрүүл аж төрөх, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний дагуу "Оюутны эрүүл мэндийг сарын дэмжих" аяныг "Эерэг хандлага- Эрүүл оюутан" уриатайгаар зохион байгууллаа. Тус аяны хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өлзийт Мандал өрхийн эрүүл мэндийн төвөөс Политехникийн коллежийн суралцагч, оюутнуудад</p>	100

	урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах				“Дэлгэцийн донтолт”, “Нойрны эмгэгээс сэргийлье”, “Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэнд”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хорт зуршлаас сэргийлэх нь” сэдвүүдээр 11 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 420 оюутнуудыг хамруулсан байна. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 84 оюутан залуусыг хамруулав.		
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асран хамгаалагч, Хорих анги, асрамжийн газар хүмүүжиж буй охид, эмэгтэйчүүдэд өсвөр үеийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох.	УТХО 0,5	Хамрагдсан иргэдийн тоо	Эрүүл мэндийн боловсрол олгосон байна		Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 1500 хүнийг хамруулан зохион байгууллаа.	50
7	Цэвэршилтийн үеийн амьдралын хэв маягийн онцлог, анхаарах асуудлуудын талаар эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн зөвлөмж, сургалт сурталчилгааг зохион байгуулах	УТХО 0,4	Сургалтын тоо хамрагдсан иргэдийн тоо	Сургалт зохион байгуулсан байна	Цэвэршилтийн үеийн амьдралын хэв маягийн онцлог, анхаарах асуудлуудын талаарх сургалт, зөвлөмжийг нийт 186 иргэнд хийж, нийт 188 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	100	
ЗОРИЛТ 5. Эх, ураг, нярай хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах							
Үйл ажиллагааны чиглэл 5.1 Эх барих эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах							
1	Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, мэргэжилтнийг жирэмсний хяналт, эх барих, нярайд үзүүлэх яаралтай тусламжийн сургалтад хамруулж, сэлгэн ажиллуулах.	-	Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо	Сургалт зохион байгуулагдсан байна.	“Жирэмслэлт төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй” удирдамжийн дагуу 2023 оны 6 сард Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч Ж.Өлзийбаяр, 2023 оны 8 сард Эх барих эмэгтэйчүүдийн эмч Б.Мөнхтуяа, 2024 оны 9 дүгээр сард эх барих эмэгтэйчүүдийн эмч О.Долгор нарыг сургалтад хамруулан сургагч багшаар бэлтгэлээ.	2023 оны 8 сард нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн бүсийн сургалтад эх барих эмэгтэйчүүдийн эмч М.Одонбаяр, нярайн эмч Б.Туяацэцэг, нярайн	100

					<p>сувилагч Д.Энхтунгалаг, 2024.09 сард эх барих эмэгтэйчүүдийн эмч О.Долгор нар хамрагдсан.</p> <p>2024.08 сард Монголын эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын холбоо, Малайзын эх барих эмэгтэйчүүдийн Нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан “Эх барихын яаралтай тусламжийн эрчимжүүлсэн сургалт”-д эх барих эмэгтэйчүүдийн эмч М.Эрдэнэзул хамрагдсан.</p> <p>2024.09 сард Монголын эх баригчдын нийгэмлэгээс зохион байгуулсан “Төрөлтийн үед үзүүлэх эх баригчийн ур чадварыг дээшлүүлэх, төрөх замын урагдал, халдвараас сэргийлэх нь” сургалтад эх баригч Т.Оюунтуяа, Б.Юмзав нар хамрагдсан.</p> <p>2024.10 сард Перинаталогийн нийгэмлэгээс зохион байгуулагдсан “Нярайн зүрх, уушгины сэхээн амьдруулалт” сургалтад нярайн эмч Б.Туяацэцэг хамрагдаж мастер сургагч багшаар бэлтгэгдсэн.</p> <p>2024.10 сард Дутуу нярайн ретинопати, нүдний улаан рефлекс илрүүлэг үзлэг хийх сургалтанд нярайн эмч, 4 нярайн сувилагч хамрагдсан. Давхардсан тоогоор нийт 10 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.</p>	
2	Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү, ХДХВ, гепатитийн В, С вирусийн халдварын илрүүлэлтийг сайжруулах.	-	Шинжилгээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь	Төрөлхийн тэмбүүгийн халдвар бүртгэгдээгүй байна.	<p>Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 398 жирэмсэн эмэгтэй хяналтад орсноос анхан шатны эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд дээр трихомониазын халдвар илрүүлэх шинжилгээнд 374 (94.0%), заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 331 (83.2%), ХДХВ болон тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 396 (99.5%), элэгний В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд 396 (99,5%) жирэмсэн эмэгтэй тус тус хамрагдсан байна. Үүнээс тэмбүүгийн шинэ өвчлөл 1 бүртгэгдснийг хяналтад авч эмчилгээнд хамрууллаа.</p>	100

3	Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх	-	Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн хувь	Илрүүлэг үзлэгийн хувийг нэмэгдүүлсэн байна.	Аймгийн хэмжээнд зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл болох хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 4801 хүн буюу нийт хамрагдвал зохих хүн амын 59,7%, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэгт зорилтот насны эмэгтэйчүүдийн 1442 буюу 62,7%-ийг тус тус хамруулаад байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэг 1,1%-иар буурсан, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэг 1,0%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт эрт ирүүлэгийн хамрагдалтын хувь 61,2	100
4	Төрөх тасагт "Имж эх" асаргааг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	Эх барихын мч, мэргэжилтэнг 90% сургасан байна.	Төрөх тасагт "Имж эх" асаргааг 10 дутуу төрсөн хүүхдэд 100 хувь хэрэглэсэн нь үр дүнтэй байсан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн 9 эх баригч, 8 сувилагч нарт "Имж Эх" сургалтыг зохион байгууллаа.	100
5	Нярайн тусламж үйлчилгээнд NOMETA-г нэвтрүүлэх.	-	NOMETA-и нэвтрүүлсэн байна.	Үр дүнг тооцсон байна.	Тэжээл нь улсын хэмжээнд тасалдал үүссэн тул хэрэглэгдээгүй болно.	ҮБ
6	Эх барих эмэгтэйчүүдийн эмчийг дурангийн мэс заслаар сургах	УТХО 3,0	Бэлтгэгдсэн эмчийн тоо	Эмч бэлтгэгдсэн байна.	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эх барих эмэгтэйчүүдийн 2 эмчийг дурангын мэс залын эмчээр бэлтгэсэн. Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал хийгдэж эхэлсэн. 2023 онд өндгөвчний уйланхай авах 2 мэс засал, 2024 онд апоплексийн мэс засал эмчилгээ 1-ийг тус тус хийгдсэн.	100
Үйл ажиллагааны чиглэл 5.2. Нярай, Хүүхдийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ						
1	Нярайн эрт илрүүлгийг чанаржуулах: • Дутуу нярайн ретинопати • Түнхний дутмаг хөгжил	-	Хамрагдсан нярайн тоо, илрүүлсэн эмгэг	Нярайн илрүүлгийн үр дүнг тооцсон байна	Дутуу төрсөн нярай бүрийг дутуу нярайн ретинопати илрүүлэх скрининг-д хамруулж эхний 10 сарын байдлаар 7 тохиолдол илэрсэн. Нийт шинээр төрсөн 449 нярайд түнхний хэт авиан шинжилгээнд хамруулж, 10 сарын байдлаар 32 түнхний дутмаг хөгжлийн тохиолдол илэрсэнг ямар ямар эмчилгээнд хамрууллаа.	100
3. Нярайн тусламж, үйлчилгээнд зөтолгоонд суурилсан үр дүнтэй арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах						
1	Сурфактант эмчилгээний тусламж үйлчилгээг сайжруулах	УТХО 3.6	Хамрагдсан нярайн тоо	Сурфактант эмчилгээний үр дүн сайжирсан байна.	Сурфактант эмчилгээний үр дүн: 2021 он - 33% 2022 он -100% 2023 он- 60% 2024 оны эхний 10 сарын байдлаар сурфактант эмчилгээ 7 хийгдсэн. Үр дүн нь 100 хувьтай байна.	100

2	Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг сайжруулах	3,0 сая	Тусламж үйлчилгээний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөө боловсруулан батлуулж, үр дүнг тооцсон байна	Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг сайжруулах 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг комиссын хурлаар хэлэлцэхэд 90,2 хувьтай байв. Тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор амьсгалж буй нярайд үзүүлэх тусламжийг үнэлэх хяналтын хуудсаар давхардсан тоогоор 45 нярайд хяналт хийхэд дундаж үнэлгээ 97,0-98,0 хувьтай байв. Эхний 10 сарын байдлаар 1 нярайн эрт үеийн эндэгдэл бүртгэгдсэн байна. НЭҮНШТ-ний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 97,0 хувьтай	100	
4.Хүүхдийн яаралтай тусламж, үйлчилгээг сайжруулах							
1	Хүүхдийн ангилалт тусламжийн сургалтыг байгуулах	эрэмбэлэн яаралтай эмнэлзүйн зохион	-	Сургалтад хамрагдсан эмч нарын тоо	Сургалт зохион байгуулагдсан байна	Хүүхдийн эмч Б.Энхбаяр, С.Золжаргал нар аймгийн нэгдсэн эмнэлийн яаралттай тусламжийн болон хүүхдийн тасаг, эх барих эмэгтэйчүүдийн тасгийн эмч, сувилагч, мэргэжилтэн нарт "Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж" ажлын байрны дадлагажих сургалтыг зохион байгуулж нийт 24 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан байна.	100
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ-98,1							

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ГАНБАТ


ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУДА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ОЮУНЧИМЭГ

ХЯНАСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Б.АЛТАНТӨГС



903-1064 x 4816129119